Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ, НИЙГМИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ШААРАВЫН ГАНТУЯАГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ***Зорилт 1.*** *Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийг төлөвлөж, зохион байгуулах зорилтын хүрээнд:* | | | | | | | |
| 1 | *ТГТ-ний 4.1.1, АТТ-ын 2.1* *Арга хэмжээ №1.1* Байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт хийсэн үнэлгээнд тулгуурлан бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны жагсаалт, албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлнэ. | Эрүүл мэндийн сайд, ЭМДҮЗ, ТАЗ-ийн шийдвэр | Чиг үүргийн шинжилгээний дүнг Төрийн албаны зөвлөлөөр зөвшөөрүүлж, зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авсан. | Оновчтой бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн зөв хуваарилалт хийгдсэн байна. | Байгууллагын бүтцийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/556 дугаар тушаал, ЭМДҮЗ ийн 2020 оны 17 дугаар тогтоол, ЭМДЕГ-ын даргын А/11 дүгээр тушаалаар бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн баталж, мөрдүүлэн ажиллаж байна. | жилдээ | 100 |
| 2 | *ТГТ-ний 4.1.2, АТТ-ын 2.6* *Арга хэмжээ №1.2* Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төсөл боловсруулж Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлуулна. | Батлагдсан тогтоол | Журмыг шинэчлэн боловсруулна. | - | Эрүүл мэндийн даатгалын улсын байцаагчийн мэргэшлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл олгох журмын төслийг бэлтгэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлсэн. | I улирал | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | *ТГТ-ний 4.1.3, АТТ-ын 1.5*<br>*Арга хэмжээ №1.3* Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | Батлагдсан хөтөлбөрийн Хэрэгжилтийн хувь | 2023 онд Нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувь. | Хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлж ажиллана. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 14 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд боловсруулагдсан 5 журмын төсөлд санал боловсруулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ. | I улирал | 70 |
| 4 | *ТГТ-ний 4.1.5*<br>*Арга хэмжээ №1.4* Ажилтнуудын ажлын үр дүн, бүтээмжийг үнэлэх ажлыг зохион байгуулж, шагнал, урамшууллын тогтолцоог бэхжүүлэх | Шагнал авсан албан хаагчийн тоо, төрөл, чанар | 2023 онд нийт албан хаагчдын 23 хувь шагнуулсан | Шагналын судалгаанд үндэслэж шийдвэрлэнэ | Ажилтан албан хаагчдын шагналын судалгааны санг бүрдүүлэн ажиллаж, салбарын баяр болон тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан шагналт тодорхойлох, уламжлах арга хэмжээг суурь судалгаанд үндэслэн шийдвэрлэж хэвшсэн. Төрийн албаны тухай, хөдөлмөрийн тухай хуулийн заалтыг үндэслэн албан тушаалын чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн 4 албан хаагчид сахилгын шийтгэл ноогдуулан, зөрчлийг давтан гаргуулахгүй байх арга хэмжээг авч ажиллаж байна. | I улирал | 100 |
| ***Зорилт 2**. Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийн хүрээнд:* | | | | | | | |
| 5 | *АТТ-ын 2.4*<br>*Арга хэмжээ №2.1.* Хүний нөөцийн чиглэлээр тушаал, албан бичгийн төсөл боловсруулах, батлуулах; | Шийдвэрийн тоо | ЭМДЕГ-ын хэмжээнд 2023 оны 365 тушаал боловсруулж батлуулсан. | Мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай хүний нөөцийг | Тайлант хугацаанд боловсон хүчний чиглэлээр гарсан 227 тушаалын төсөл бэлтгэн батлуулсан. Албан хаагчийг албан тушаалд томилох, | I улирал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүрдүүлж ажилласан байна. | чөлөөлөх, шилжүүлэн ажиллуулах, дэвшүүлэх, чөлөө олгох, тэтгэмж урамшуулал олгох зохицуулалтыг хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллалаа | | |
| 6 | *АТТ-ын 1.3*<br>*Арга хэмжээ №2.1* Төрийн албаны зөвлөлийн тогтоол, зөвлөмжийг хэрэгжүүлэх, агентлагийн хэмжээнд хүний нөөцийг бүрдүүлэх, төлөвлөх ажлыг зохион байгуулна. | Ирүүлсэн тогтоолын хүрээнд гаргасан шийдвэрийн тоо, үр дүн | Сонгон шалгаруулалтын дүнд 2-3 тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан | Тогтоол, журам зөвлөмжийг мөрдөж ажилласан байна. | Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлд албан тушаалын сул орон тоо нөхөх захиалгыг хүргүүлэн, тусгай шалгалтыг хамтран зохион байгуулж, тус салбар зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор гүйцэтгэх 2 албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу нөхөж ажиллалаа. | I улирал | 100 |
| 7 | *АТТ-ын 2.3*<br>*Арга хэмжээ №2.2.* Төрийн албан хаагчдын цалин, нэмэгдэл хөлс, зэрэг дэв олгох, нэмэгдүүлэх санал боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлэх шийдвэрлүүлэх; | Шинэчилсэн тушаал, хүргүүлсэн саналын тоо | 2023 онд 42 албан хаагчид зэрэг дэв олгуулсан | Шинээр батлагдан гарсан тогтоолтой уялдуулан цалинг шинэчлэн тогтооно. | Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан ЭМДЕГ-ын даргын 2024 оны А/57 дугаар тушаалаар албан хаагчдын цалинг шинэчлэн батлуулж, ХНУМТ /хүний нөөцийн/ цахим системд цалинг шивж баталгаажуулав. Тус агентлагийн төрийн үйлчилгээний ангиллын нийт 31 ажилтанд ур чадварын нэмэгдлийг 25 хувиар тооцон олгож байна. | I улирал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | *ТГТ-ний 4.1.7, АТТ-ын 2.2 Арга хэмжээ №2.3.* Байгууллагын хүний нөөцийн бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажилд томилох, чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулах; | Албан хаагчдын тоогоор-285 | Томилж чөлөөлсөн шийдвэрийг хуулийн үндэслэлтэй боловсруулсан байна. | Сул орон тоог судалж захиалгыг салбар зөвлөлд хүргүүлж, нэр дэвшүүлсэн албан хаагчдыг томилно. Хуулийн хүрээнд томилж чөлөөлнө. | Төрийн албаны зөвлөлийн Эрүүл мэндийн яамны дэргэдэх салбар зөвлөлд албан тушаалын сул орон тоо нөхөх захиалгыг хүргүүлэн, тусгай шалгалтыг хамтран зохион байгуулж, тус салбар зөвлөлийн 2024 оны 03 дугаар тогтоолоор гүйцэтгэх 2 албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу нөхөж ажиллалаа. | I улирал | 100 |
| 9 | *ТГТ-ний 4.1.7, АТТ-ын 3.2 Арга хэмжээ №2.8* Өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад тусламж, дэмжлэг олгох, хүндэтгэл үзүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах; | Тэтгэмж, урамшуулал, арга хэмжээний тоо | Жилд 2-3 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна | Сар шинийн баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | Тус агентлагийн хэмжээнд 2024 онд 9 албан хаагч тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлж, холбогдох төсвийн тооцоог боловсруулсан. 2025 онд тэтгэвэр тогтоолгох 8 албан хаагчдын судалгааг гаргаж тэтгэмжийн төсвийг тооцуулсан. | I улирал | 100 |
| 10 | *Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.1.7, Албан тушаалын тодорхойлолтын 3.2 Арга хэмжээ №2.9* Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээний биелэлт үр дүнг тооцох. | Гэрээ байгуулсан албан хаагчдын тоо | Төрийн үйлчилгээний албан хаагчидтай байгуулсан байна. | Хуульд нийцүүлэн боловсруулсан байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийг үндэслэн албан хаагчидтай байгуулах хөдөлмөрийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулж гэрээ байгуулахад бэлэн болгосон | I улирал | 70 |
| ***Зорилт 3.*** *Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах зорилтын хүрээнд:* | | | | | | | |
| 11 | *ТГТ-ний 4.1.21, АТТ-ын 4.6* ***Арга хэмжээ 3.1*** Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг чанд мөрдөн ажиллах, ажил үүргийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг эмхлэн цэгцэлж, архивлах; | Шийдвэрлэлтийн хувь | 2023 онд албан бичиг-8, өргөдөл-160 шийдвэрлэсэн | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын хүрээнд баримт бичгийг стандартын дагуу цэгцлэн 1 дүгээр улиралд архивт | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг үндэслэн хүний нөөцийн чиглэлээр гарсан баримт бичгүүдийг эмхлэн хадгаламжийн нэгж бүрдүүлэн архивын ажилтанд жагсаалтаар хүлээлгэн өглөө | I улирал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шилжүүлсэн байна. | | | |
| 12 | *ТГТ-ний 4.1.11, АТТ-ын 4.7* **Арга хэмжээ 3.2** Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын соёл, дэг журмыг чанд сахиж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх; | Алдаа зөрчилгүй ажилласан байх | Алдаа зөрчилгүй ажилласан | Хөрөнгө орлогын мэдүүлэг, тайлбарыг хугацаанд нь тайлагнасан, хувь хүний нууцын тухай хуулийг чанд мөрдөж ажилласан байна. | ТАТХ болон бусад хуулиар зохицуулсан хэм хэмжээг мөрдөж, алдаа дутагдал гаргалгүй ажиллаж байна. | I улирал | 100 |
| 13 | *ТГТ-ний 4.1.26, 4.1.29, АТТ-ын 4.4* **Арга хэмжээ 3.3** Газар, хэлтсийн хэмжээнд болон чиг үүргийн хүрээнд явагдах семинар, зөвлөгөөн, өдөрлөг, сургалтын зохион байгуулалт, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох; | Арга хэмжээний тоогоор | Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд оролцоно. | Цаг үеийн шинжтэй хурал болон мэдээллийн цаг, сургалтуудад бүрэн хамрагдсан байна. | Удирдлагын Академийн Хүний нөөцийн менежмент сэдэвт сургалтанд хамрагдахын зэрэгцээ ТАЗ-ийн зохион байгуулдаг Пүрэв гарагийн сургалт болон байгууллагын мэдээллийн цагт тогтмол хамрагдаж байна. УА-ын Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдаж байна. | I улирал | 100 |
| ***Дөрөв.** Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:* | | | | | | | |
| 14 | *Арга хэмжээ №4.1* Шинээр ажилд томилогдох албан хаагчдын ХАСУМ хянуулах, дүгнэлт авах; | Албан хаагчдын тоогоор | Шинээр томилогдсон төрийн албан хаагчид дүгнэлт гаргуулсан байна | Төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдох албан хаагчдаас урьдчилсан мэдүүлэг гаргуулах. | Төрийн захиргааны албан тушаалд томилогдон ажиллах 36 албан тушаалны ХАСУМ-ыг нээж баталгаажуулан албан бичгээр АТГ-т илгээж дүгнэлт гаргууллаа | I улирал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | *Арга хэмжээ №4.2* Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдүүлэг тайлбарыг авах, бүртгэх; | Тайлбар гаргасан албан хаагчдын тоогоор | Журмын дагуу тайлбар, мэдүүлэг гаргасан байна. | Ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдалд тайлбар гаргасан байна. | Хяналт шалгалт хийх шалтгаанаар ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдүүлсэн 28 албан хаагчийн мэдүүлгийг системд бүртгэсэн. | I улирал | 100 |
| 16 | *Арга хэмжээ №4.3* Төрийн захиргааны албан хаагчдаас Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулах, тайланг нэгтгэх. | Мэдүүлэг гаргасан албан хаагчдын тоогоор | 2023 онд 167 албан хаагч ХАСХОМ мэдүүлсэн | Хуулийн хугацаанд мэдүүлэг тайлбарыг гаргаж ажилласан байна. | Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг бүрдүүлэлтийг хуулийн хүрээнд зохион байгуулж тайланг 2024 оны 01/795 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | I улирал | 000 |

**Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дуусссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.1 Байгуулагын удирдах ажилтны сургалт зохион байгуулах | Сургалтанд хамрагдах ажилтны тоо | 2023 онд 1 удаа зохион байгуулагдсан | 90-ээс дээш хувь хамрагдсан байна. | Байгуулагын удирдах ажилтны сургалт зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд оролцвол зохих удирдах ажилтнуудын 97 хувийг хамруулан зохион байгуулаа. | 05 сард | 100 |
| 18 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.2 “Эмч танаараа бахархья-2024” арга хэмжээний зохион байгуулалтанд оролцох | Оролцогчдын ирц | 1000 эмчийн чуулган зохион байгуулагдсан | 90-ээс дээш хувь хамрагдсан байна. | Эрүүл мэндийн яамтай хамтран ЭМДЕГ-ын 15 албан хаагчийг ахлан уг арга хэмжээний зохион байгуулалтанд оролцож ажилласан. Байгууллагаас төлөөлөгчөөр оролцох албан хаагчдын нэрсийг ЭМЯ-нд гарган хүргүүлж, оролцоог бүрэн хангаж ажилласан | 03 сард | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.3 “Сувилагч танаараа бахархья-2024” арга хэмжээний зохион байгуулалтанд оролцох | Оролцогчдын ирц | Урьд зохион байгуулагдааггүй | 90-ээс дээш хувь хамрагдсан байна. | Эрүүл мэндийн яамтай хамтран ЭМДЕГ-ын 15 албан хаагчийг ахлан уг арга хэмжээний зохион байгуулалтанд оролцож ажилласан. | 03 сард | 100 |

**Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | *ТГТ-ний 4.1.4, АТТ-ын 4.12*<br>**Арга хэмжээ 2.1** Газар, хэлтсийн хэмжээнд болон чиг үүргийн хүрээнд явагдах семинар, зөвлөгөөн, өдөрлөг, сургалтын зохион байгуулалт, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох; | Арга хэмжээний тоогоор | Сургалтын хөтөлбөр батлагдсан. | Цаг үеийн шинжтэй хурал болон мэдээллийн цаг, сургалтуудад бүрэн хамрагдсан байна. | Удирдлагын Академийн Хүний нөөцийн менежмент сэдэвт сургалтанд хамрагдахын зэрэгцээ ТАЗ-ийн зохион байгуулдаг Пүрэв гарагийн сургалт болон байгууллагын мэдээллийн цагт тогтмол хамрагдаж байна. | 05 сард | 100 |
| 2 | *ТГТ-ний 4.1.4, АТТ-ын 4.12*<br>**Арга хэмжээ 2.2** “Төрийн албаны тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулийн хүрээнд батлагдсан дүрэм, журмыг судалж, танилцах; | Дүрэм, журмын тоогоор | Шинээр батлагдсан тогтоол шийдвэрүүдийг бүрэн судалсан | Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хууль, эрх зүйн хүрээнд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. | Төрийн албаны хуультай холбогдон гарсан дүрэм журмуудыг судалж, ашиглаж байна. | тухай бүр | 80 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ, НИЙГМИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ........................ Ш.Гантуяа 2024...................